

**ОНОЛ БОЛОН ПРАКТИКИЙН ТААТАЙ НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ НЬ:
ХОРШООЛОЛ АМЖИЛТАД ХҮРЭХЭД ХОРШООЛЛЫН ЭРХ ЗҮЙ
ШААРДЛАГАТАЙ, ХАНГАЛТТАЙ ЭСЭХ.**

Хаген Хенри, Хоршооллын хуулийн мэргэжилтэн, Финлянд
2002 оны 5 дугаар сар

Олон улсын тодорхойлолтын дагуу хоршоолол гэж хамтын эзэмшил, хяналтад байх аж ахуйн нэгжийг ажиллуулснаар өөрийн гишүүдийн эдийн засаг, нийгэм соёлын хэрэгцээг хангах зорилготой, бие даасан, өөртөө туслах бүлгүүдийг нэрлэдэг. Гэвч сүүлийн жилүүдэд гарсан эдийн засаг, нийгэм, улс төрийн өөрчлөлт, даяаршлын нөлөө зэрэгтэй холбогдуулан хоршооллын өөртөө туслах потенциалыг дутуу ашиглаж ирсэн, тэр ч байтугай орхигдуулсан гэсэн дүгнэлтэд олон улсын байгууллагууд, засгийн газрууд, бусад байгууллагууд хүрсэн юм. Хоршооллын өрсөлдөх чадвар, өөртөө туслах чадварыг нэмэгдүүлэхэд таатай орчин буюу улс төр, хууль эрх зүйн, захиргааны зохицуулалт шаардагдах нь тодорхой болж байна. Энэхүү илтгэлд хоршооллын эрх зүйн тухай ярилцана.

Хоршооллын эрх зүй дан ганцаар хоршооллыг амжилттай болгож чадахгүй. Хоршооллууд амжилттай Норвеги, Дани зэрэг зарим улсад хоршооллыг тусгайлан зохицуулсан хууль байдаггүй хэдий ч тодорхой хэмжээний хуулийн зохицуулалтгүйгээр хоршооллын хөдөлгөөн амжилтад хүрсэн тохиолдол үгүй. Үүний гол учир шалтгаанаас тоочиход, хоршооллын тухай үндэсний хуульд заавал баримтлах стандартыг тогтоосон хоршооллын олон улсын нийтийн эрх зүй /хүний эрхийн актууд, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 141, 127 дугаар Конвенц, 127 тоот зөвлөмж/ бүрэлдсэн, хүний эрх, хууль дээдлэх, ардчиллыг эрхэмлэж байгаа энэ үед хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд ба төр засгийн хоорондох эрх зүйн харилцааг парламентын актаар зохицуулах ёстой, хоршооллын эрх зүй нь хоршооллын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл зэрэг юм.

Хоршооллын эрх зүйн зохицуулалтын хүрээнд өөртөө туслах /self-help/ бүх хэлбэр бус харин зөвхөн хоршооллын байгууллагууд хамрагдаас хамгийн оновчтой юм. Өөртөө туслах бүх хэлбэрийг зохицуулсан түгээмэл хуулийг хэрэгжүүлнэ гэдэг нь бэрхшээлтэй.

Нийтийн эрх зүй, хувийн эрх зүйн хоорондын ялгаа өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн зүйл биш хэдий ч хоршооллын тухай хуулийн мөн чанар нь ямар харилцааг зохицуулахаас шалтгаалдаг учиртай гэж хэлж болно. Хэрэв энэ нь хоршооллын зохион байгуулалт зэрэг дотоод асуудлуудыг зохицуулахын зэрэгцээ хоршооллын төрийн дээд байгууллагын эрх дарх зэргийг зохицуулбал нийтийн /public law/ эрх зүйн салбар болно. Хоршооллын хуулийг хувийн буюу нийтийн эрх зүйн хүрээнд боловсруулах нь улс төрийн сонголт юм.

Хоршоолол бие даасан байдалтай байх болон хууль дээдлэх зарчмыг баримтлах үүднээс хоршооллыг зөвхөн хуулиар зохицуулах ёстой юм. Улс орнууд урьд өмнө хуулийг хөгжүүлэх онолыг хөгжлийг дэмжих хуулийн онолоос илүүд үзэх сөрөг явдал гарч байсан билээ. Харин одоо хөгжлийг дэмжих хуулийн тухай онолыг буруугаар ойлгосноос хоршооллын тухай хуулийн хамгийн чухал

хэсгүүдийг засгийн газрын актаар өөрчлөх явдал гарч байна. Хуулиар зохицуулагдаагүй нийгмийн харилцааг хуульчилсан актаар бөглөж улмаар хуулийн мөн чанарыг алдагдуулахад хүргэх тул хоршооллын хуулийг аль болох тодорхой заалттай боловсруулах нь зүйтэй юм.

Дэлхийн улс орнууд одоогийн байдлаар хоршооллын нэг түгээмэл хууль, хоршооллын янз бүрийн төрлийн тухай хэд хэдэн хууль, бүр ямар ч тусгай хууль үгүйгээр хоршооллыг зохицуулсан байдаг. Тухайн улсын иргэний, арилжааны хууль буюу бусад хуульд хоршооллын асуудал бүрэн хэмжээгээр тусгагдсан нөхцөлд тусгай хоршооллын хууль хэрэггүй байж болох юм. Гэсэн хэдий ч дэлхийн төлөв байдал нэг түгээмэл хууль тогтоох тогтолцоонд шилжиж байна. Үүнийг хэдэн хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно – бүх төрлийн хоршооллыг нэг хуулиар зохицуулсанаар хоршооллын бие даасан байдлын хамгийн сайн баталгаа болж өгнө, хүнд суртлыг багасгана, олон хуулиар зохицуулах нь хоршооллын хөдөлгөөнийг задраах аюултай гэх мэтчилэн.

Хоршооллын зохион байгуулалтын ерөнхий бүтцийг заасан товч хууль нь бусад хуулиас ишлэл татахыг шаарддаг тул тухайн хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж, ойлгоход бэрх болгох аюултай. Тийм ч учраас тодорхой заалттай хууль нь ашигтай гэж үзнэ. Харин хэт их нарийвчилсан заалттай хууль зарим талаар сөрөг нөлөө үзүүлдэг. Ийм хууль улс орны хөгжлийн үйл явцад гарах эдийн засаг, нийгэм, улс төрийн өөрчлөлтийг тусгаж чаддаггүй тул, түүнийг дахин дахин өөрчлөн засварлах шаардлага гарч, хүч хөдөлмөр ихээр шаардаж, хуулийн нэр төр унаж улмаар хоршооллын хөдөлгөөнд сөргөөр нөлөөлнө. Хууль боловсруулахад түүний дотоод бүтцэд мөн багагүй анхаарал хандуулах нь зүйтэй мэт санагдана, чингэхдээ хуулийг хэрэгжүүлэх, хуулиар зохицуулагдах талд зориулж аль болох хялбарчилсан байдлаар зохиовол зүйтэй юм.

Хоршооллын тухай хууль тогтоох үйл явцад олноор оролцох арга барил хамгийн тохиромжтой бөгөөд энэ нь сүүлийн үед газар авч байна. Тухайлбал, Камерун, Канад зэрэг улсуудыг нэрлэж болно. Зарим улсууд энэ арга барилыг институтчлэн хоршооллын асуудлаар үндэсний зөвлөл зэргийг байгуулсан байна. /Бельги, Франц, Мали/

Хоршооллын эрх зүй нь төрийн эрх, хоршооллын бие даасан байдал зэргийг хослуулах ёстой юм. Өөрөөр хэлбэл төрийн эрх нь хоршооллын бүртгэлийг хийх, хууль зөрчсөн хоршооллыг бүртгэлээс хасах зэрэгт оршиж байхад хоршооллын бие даасан байдал нь санхүүгийн бие даасан байдал, эдийн засгийн амжилт, хоршооллын гишүүдийн дотоод хяналт зэргээс бүрдэнэ. Хоршооллын эрх зүйд шаардагдах хамгийн чухал зүйл нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн шалгууруудад тулгуурласан хоршооллын оновчтой тодорхойлолт, ялангуяа бусад аж ахуйн байгууллагуудаас ялгарах шалгуурууд зэрэг байдаг. Хоршооллын дэлхийн түгээмэл зарчмууд улс орнуудын соёлын онцлогийг хөндөх ёсгүй.

Хоршооллын тухай хууль тогтоомжууд гэдэг нь тухайн улс орны эдийн засаг, улс төрийн үндсэн санаа, хоршооллын онол, зарчим, хоршооллын эрх зүй зэргийн харилцан хамаарлыг тусгасан систем юм. Хоршооллын хууль тогтоомж гэдэг нь хоршооллын эрх зүйгэс илүү явцуу ойлголт бөгөөд түүний нэгэн хэсэг юм. Хоршооллын эрх зүй нь тодорхой хэдэн хууль тогтоомжийн цогцолбор бус

харин бүхий л үндэсний хууль, олон улсын хууль, захиргаа, шүүхийн актууд болон хоршооллын гишүүдийн нийтээр хүлээн зөвшөөрсөн болон тогтсон практик зэргийг хамардаг өргөн хүрээний ойлголт юм. Хоршооллын тухай хууль үр ашигтай байлгахын тулд түүнийг бусад хууль тогтоомжтой, нэн ялангуяа нийгмийн болон хөдөлмөрийн хуультай уялдуулан боловсруулах хэрэгтэй байдаг.

Хоршооллын тухай хууль боловсруулснаар хоршооллын хөдөлгөөнд тэр даруй аливаа ахиц гарахгүй нь ойлгомжтой юм. Хоршооллын тухай хуулийг хэрэгжүүлэхэд түүний тухай, хоршооллын тухай мэдлэгийг ард түмний дунд түгээх явдал хамгийн чухал байдаг, энэ үүргийг засгийн газар, хоршооллын хөдөлгөөн аль аль нь биелүүлэх ёстой. Энэ хүрээнд зарим орнууд улс даяар кампанит ажил зохиох, удирдамж хэвлэж гаргах зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Энэ илтгэлд тэмдэглэсэн зүйлсийг хэрэгжүүлэхэд тухайн улс орны соёлын онцлогийг харгалзах нь зүйтэй юм. Хоршооллын тухай хууль тогтоох арга барил, хоршооллын хөгжлийн хүчин зүйлсийн харилцан нөлөө зэргийн тухай мэдээллийг гадаадаас өгч болох боловч тэдгээр зөвлөмжийг тухайн улс орны өвөрмөц нөхцөл байдалд тохируулах, шаардлагатай өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн дотоодод шийдвэрлэнэ. Хоршооллын тухай янз бүрийн бүрийн хуулийн нэгдмэл байдлыг хангасанаар хоршооллын өвөрмөц байдлыг сахин хадгалах, тулгамдсан асуудлыг хуульчид хүлээн зөвшөөрөх шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд хоршооллын тухай мэдлэг олны дунд нэмэгдсэн боловч энэ нь хувьцаат компаний тухай мэдлэгтэй харьцуулашгүй хэвээр байна. Хэдий ч орчин цагийн оюуны үйлдвэрлэлийн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хяналтын дутагдал илэрхий болж байгаа тул, эдийн засгийн онол хоршооллын зохион байгуулалтын давуу талд анхаарлаа хандуулах болно.

**Хоршооллууд болон тэдний дээд байгууллагууд
орон нутгийн, индэсний болон олон улсын
твшинд таатай орчинг хэрхэн сайжруулах талаар
Рави Шакар
/Энэтхэг/**

Энэхий илтгэлд хоёр чухал зэргийн тухай ярилцана: хоршооллыг хөгжүүлэхэд нөлөөлөх таатай орчин гэдэг ойлголт болон таатай орчин бий болгох зарим гол нөхцөлд.

Төрөөс зах зээлийн эдийн засгийн бодлогоо хэрэгжүүлэхдээ хоршооллыг хөгжүүлэх таатай орчин бий болж байна уу гэдгийг тодорхойлох шаардлагатай. Ийнхүү холбогдуулан тэрхүү таатай орчинг бий болгоход тус улсын тийхэн хөгжил нөлөөлж байна уу, өөрийн эдийн засгийг хөгжүүлэхдээ ямар замаар замнаж байсан: төвлөрсөн эдийн засгийн загвар, нийгмийн социалист загвар, холимог загвар, капиталист загвар болон/эсвэл засгийн газрын оролцоог хязгаарлаж байсан уу? гэдгийг анхаарах хэрэгтэй.

Хоршооллыг хөгжүүлэх болон амжилттай ийл ажиллагаагаа явуулахад нөлөөлөх бас нэгэн гол хичин зийл бол шийх засаглал юм. Шударга, чөлөөтэй шийх засаглал нь хоршооллыг өөрөө бие даан хөгжихөд нь эрх зийн дэмжлэг иийлэх твшинд нөлөөлдөг.

Хоршооллын хэлбэрийн байгууллагуудыг хөгжүүлэхэд таатай орчин бий болгох нөхцөл нь дийлэнх тохиолдолд тус улсын Индсэн хуульд заагдсан байдаг. Эдгээр таатай орчин бий болгох суурь нь иргэний эрх чөлөө нь тус улсын тусгаар тогтнол, бйрэн эрхт байдал, нийгмийн дэг журам, ард тймний ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй болон индэсэлэлтэй хязгааралт гэдэг ойлголтод багтах ёстой юм. Хоршооллыг дэмжих дараагийн нөхцөл нь тус улсын хоршооллын тухай хууль болон бусад хууль тогтоомжууд хоршооллын ийл ажиллагаа, хөгжилд хэрхэн нөлөөлж буйд оршино. Таатай орчин нь их хэмжээгээр хоршооллын бодлогын индэс болон төрийн бодлогод хоршооллын талаарх заалтын эзлэх байр, чухалыг хэрхэн тусгасан нь бас хамаарна. Хоршооллын талаарх бодлого болон хууль тогтоомжийн гол ялгаа нь эхнийх нь засгийн газрын хариуцлага болон эрх мэдлийн асуудал бол дараах нь Парламент болон хууль тогтоогчдийн эрх мэдлийн асуудал юм. Мэдээж хоршооллыг хөгжүүлэхэд таатай орчин нь орон болгонд өөрийн гэсэн онцлогтой. Тэр нь тус улсын төрийн тогтолцоо болон нийгэм эдийн засгийн байдлаас хамааралтай байдаг.

Хоршооллыг хөгжүүлэхэд ерөнхий орчинд сийлийн арав гаруй жилд өрнөсөн асар их өөрчлөлтүүд ихээр нөлөөлсөн. Дэлхийн худалдааны байгууллага 1995 онд бий болсоноос хойш хоршооллууд зах зээлд өөрийн байр сууриа шинээр ирэлхийлэхэд хйргэсэн юм. Шинэ орчин нь эдийн засагт оролцочдод тэгш бус бөгөөд тэдний байр суурь хамгийн муу байгааг ялангуяа, хөгжиж буй орнуудын хоршооллууд ойлгосон юм. Эдийн засгийг либералчлахад төрийн оролцоог сулруулж чадахгүй байна. Энэ нь хоршооллыг хөгжүүлэхэд таатай орчин бий болгох

хууль тогтоомж, төрийн бодлогийг шинэчлэх асуудал засгийн газруудын мөрийн хөтөлбөрт тэргүүлэх чиглэл болдоггүйгээр батлагдана. Даяаршлын явцад зах зээл болон түүхий эдийн төлөө тэмцэл бий боллоо: нэг талаас үндэстэн дамнасан хөрөнгийн зах зээл, нөгөө талаас орон нутгийн, үндэсний зах зээлийг хангадаг орон нутгийн бизнес, хоршооллууд болон тэдний дээд байгууллагууд. Энэхүү шинэ нөхцөлд хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудын хоршооллууд идэвхтэй ажиллаж амжилтанд хирэх ёстой юм.

Одоо Монгол Улсад хичин төгөлдөр үйлчилж буй Хоршооллын тухай хууль 1994/1995 онд батлагдсан юм байна. Монголын Хоршооллын тухай хуулийг урьдчилан харахад НҮБ-ын тогтоолууд болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын хоршооллын талаарх зөвлөмжүүдээс ихээхэн хэмжээгээр зөрж байна. Интернет болон бусад эх сурвалжаас олдож буй хязгаарлагдмал материалуудаас Монголын Засгийн газар хоршооллын талаар бодлогоо тодорхойлсон нь, төрийн бодлого байдаг эсэх, хэрэв байдаг бол тэрхүү бодлогод хоршооллын болон хоршооллыг хөгжүүлэх талаар заалт байдаг эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Түүнчлэн Монголын хоршооллын хөдөлгөөний талаар мэдээллийн сан байдаг эсэх нь мэдэгдэхгүй байна.

Хоршооллыг хөгжүүлэхэд таатай орчин бий болгоход өнөөгийн байгаа байдлыг үнэн зөвөөр гүйцэд судлах шаардлагатай. Тэгснээр үндэслэл сайтай зөвлөмж гаргана. Өнөөгийн байдал болон цаашдын хийх ёстой зүйлийг тодорхойлсны дараа үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулна.

Хоршооллууд болон тэдний дээд байгууллагууд зөвхөн бусад хоршооллуудтай хамтран ажиллахын зэрэгцээ хоршооллыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадахуйц байгууллагууд /санхүүгийн институт, академи, сайн дурын байгууллагууд/-тай холбоо тоогтоож хамтран ажиллах хэрэгтэй. Гэхдээ хоршооллын үндсэн зарчим болдог бие даасан байдал, хамтран ажиллах болон өөрөө өөрийгөө удирдах зарчмуудыг зөрчихгүй байхыг анхаарах хэрэгтэй. Хоршооллууд өөрийн дотоод хэрэгт оролцох гэсэн бүүхий л оролдлогыг зогсоох хэрэгтэй.

Хоршооллууд болон тэдний дээд байгууллагууд хууль ёсны арга замаар бүх үндэсний болон бүс нутгийн улс төрийн намуудыг хоршооллын талаарх өөрийн байр сууриа сонгуулийн өмнөх сурталчилгаандаа мэдэгдэл гаргаж, төрийн эрх авсан бол шардлагатай үед нь орчинг улам таатай болгохын тулд нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж байхыг шаардаж байх хэрэгтэй.

Хоршооллын дээд байгууллагууд зохион байгуулалт, гишүүдийнхээ удирдлагыг сайжруулах тал дээр ажиллах хэрэгтэй, тэгснээр засгийн газраа таатай орчин бий болгоход дэмжих хууль зүйн болон бодлогын өөрчлөлт хийхэд хиргэнэ.

Хоршоолол мэргэжсэнээр өөрийн гишүүдэд сайн үйлчилж, эдийн засгийн үр дүнгээ сайжруулахад хирнэ. Үүний тулд тэд сүүлийн үеийн менежментийн технологи, арга барил, стратегийн ололтуудыг өөрийн үйл ажиллагаа, зорилтондоо ашиглах хэрэгтэй.

Хэвлэллийн болон электрон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн дэмжлэг бол хоршооллыг хөгжүүлэх таатай орчинг бий болгож, тогтвортой байлгах чухал арга замуудын нэг нь юм.

Хоршооллууд еерийн гишүүдийн эрэлт хэрэгцээ, хисэл эрмэлзэлийг хангаж чадах юм бол еерийн таатай орчинг сайжруулна. Ингэснээр хоршооллуд болон дээд байгууллагууд нь еерийн гишүүдэд эргээд чанартай ийлчлэх болно.

Хоршооллын хеделгее нь таатай орчин бий болтол хилээх ии эсвэл ийл ажиллагаагаа таатай биш орчинд эхлүүлэх ии гэдэг асуулт нээлттэй илдэж байна.

Хоршоолол нь даяаршил, либеральчлалын ир динд хохирч буй химист тусалж дэмжих иирэгтэй учир хамгийн тиринд ир динд хирч, итгэлийг нь олсноор еерийн таатай орчинг бий болгож чадна.

Тившин бир дээрээ таатай орчингоо сайжруулахдаа харилцан дэмжих зарчим баримтлах шаардлагатай юм. Ингэснээр хоршооллууд болон тэдний дээд байгууллагууд еерсдийн орчингоо байгаа бололцоогоороо ир динтэй, амжилттай сайжруулж чадах юм.

**Хоршооллыг дэмжих орчны онцлог, боломж
Ибное Соиджоно**

/Индонезийн Хоршоолол судлалын хирээлүи/

Хоршоолол нь нээлттэй систем учраас нийгэм, эдийн засаг, улс төрийн нөлөөлөөс ангид байж чадахгүй. Хамгийн тохиромжтой нөхцөлд бол засгийн газар нь хоршооллыг өөрийн зорилготой нийцдэг, бусад бизнесийн хэлбэрүүдтэй тэгш ижил бололцоо олгох, хоршооллыг хөгжүүлэхэд таатай орчин бий болгож, дэмжлэг үзүүлдэг байх юм.

Бээжин хотноо 1999 оны 10-р сард болсон Ази Номхон Далайн орнуудын хоршооллын асуудлаарх сайд нарын 5 дугаар бага хурлаар хоршоолол нь хиймэл нийгмийн хангамж, ажлын байр, бизнес хийх бололцоо бий болгож, эдийн засгийн дэмжлэг үзүүлж байна гэдгийг хилээн зөвшөөрсөн юм. Цаашилбал, ирээд амжилт үзүүлэх хоршооллын хувь нэмэр нь зөвхөн эдийн засагт бус нийгмийн эрх тэгш, шудрага байдал, хариуцлагыг дээшлүүлдэгт оршино. Тийнчлэн, хоршоолол нь жинхэнэ ардчилсан нийгмийн зохион байгуулалтын жишээ болохоос гадна энх тайван, нийгмийн тогтвортой байдлыг ч хангахад хувь нэмрээ оруулдаг байна. Оршооллын тодорхойлолыг Манчестер хотноо хуралдсан Олон улсын хоршооллын нийгэмлэгийн 100 дугаар их хурлаар баталжээ.

Оршооллын өсөлт нь засгийн газрын үйлдвэр дэмжлэг үзүүлэгдэх ёстой. Энэхүү дэмжлэг нь төрийн бодлогын төвшинд хоршоололд засгийн газрын үйлдвэр хугацааны зорилготой нийцсэн байх ёстой юм. Хоршооллыг дэмжихдээ засгийн газар нь бодлогоо гийцэд биелүүлнэ гэсэн үг биш юм. Тиймд засгийн газрын хөтөлбөрийг дэмжих үүргээ хоршоолол биелүүлэхдээ гишүүдийнхээ ашиг сонирхол, хоршооллын зорилготой зерчилдэх ёсгүй юм. Засгийн газрын дэмжлэг нь хоршооллыг бие даасан байдал, эрх чөлөөгөө алдахад хиргэх болон өөрөө өөрийгөө хөгжүүлэх бололцоог нь үгүйсгэж болохгүй юм. Хоршооллын тогтмол санаж байх ёстой зүйл - засгийн газар хоршооллыг хичнээн дэмжиж байсан ч улс төрийн институт хэвээрээ үлддэг. Тиймд хоршоолол нь засгийн газрын бодлогын ямар нэгэн өөрчлөлтөөс хамааралгүй бие дааж үлдэхийг эрмэлзэх явдал юм. Энэ нь тийм ч хялбар зүйл биш нь ойлгомжтой.

Засгийн газрын дэмжлэгийн хэлбэрээс үл хамааран хоршооллыг бие даасан, өөрөө өөрийгөө дэмжих институт хэвээр нь авч үлдэхийг зорих ёстой юм. Ийм бодлогын үр дүнд хоршооллыг хариуцдаг байгууллага нь багасч, үйл ажиллагаа нь зөвхөн зохицуулах үүрэгтэй болно. Харин хоршоолол нь зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд өргөжих юм. Засгийн газар хоршоололд үйлдвэр үйлдвэр дэмжлэг үзүүлж болно:

- Хоршооллын тухай хууль тогтоомж: хамгийн эхний болон чухал дэмжлэг бол хоршооллыг хууль ёсны, бие даасан, бусад аж ахуйн нэгжээс онцлог аж ахуйн нэгж юм гэж хилээн зөвшөөрсөн Хоршооллын тухай хууль юм. Хууль тогтоомжтой

холбогдолтой хоёр зүйл байнга байдаг: нэгд, тал талын ашиг сонирхолыг багтаасан хууль нь улс төрийн бичээгдэхийн юм; хоёрт, хоршооллын талаарх засгийн газрын эрх мэдлийг хязгаарлах. Хоршоолол нь төрөл бүрийн салбарт ийл ажиллагаа явуулдаг учир хоорондоо ялгаатай янз бүрийн хууль тогтоомжийг биелүүлэх болдог учир *хоёр сонголт* байж болох юм.

Хоршоолол нь хөрөнгөн дээр бус, гишүүнчлэл дээр суурилдаг байгууллага, бие даасан байдал, олон улсын хэмжээнд хилээн зөвшөөрөгдсөн хоршооллын тодорхойлолт, зарчмыг хууль ёсных гэж хилээн зөвшөөрөх, засгийн газар хоршооллын хөдөлгөөний бичээц, менежмент, ийл ажиллагаанд нь саад учруулахгүй байх.

Засгийн газар хуулийн дагуу л ажиллах эрхтэй, зөвхөн бичрэгэх, хуулийн дагуу хилээн зөвшөөрөх, хууль зөрчсөн хоршооллыг тараах болон талууд хуулиар хилээн зөвшөөрсөн ийргээ биелүүлэхийг хянах.

Хяналтын дагуу хоршооллууд дотоод гадаад аудитын шалгалтаар орох ийрэгтэй. Хуулийг олон янзаар тайлбарладаг нь аль аль тал нь хоршооллын мөн чанарыг мэддэгитэй холбоотой юм. Шийгч, хоршоолол хариуцсан албан хаагч болон хоршооллын төлөөлөгч орсон зөрөлдсөн шийдвэрлэх зөвлөл бий болгох шаардлагатай.

Сургалт боловсрол: хоршооллын амжилт, алдаа нь гишүүдийн чанар чансаанаас их хамааралтай. Гишүүдийн сургалт боловсрол нь хоршооллыг байгууллага, аж ахуйн нэгж гэдэг утгаараа ир динтэй ажиллүүлэхээс гадна иргэний нийгмээ хөгжүүлэх, хууль ёсоо дээдлэх, сайн ардчилагч, сайн иргэн болоход тус болдог. Хоршооллын сургалтыг бага сургуулиас эхлээд дээд сургууль хичрүүл заах нь хоршооллын хөдөлгөөнд дэмжлэг, хандив болно.

Эдийн засгийн ийлчилгээний зардал: хоршоолол хичтэй орнуудад, хоршооллууд өөрийгөө дэмжих зорилгоор банк, даатгал г.м. ийлчилгээ бий болгодог байна. Хоршоолол хөгжиж байгаа орнуудад бол засгийн газрын талаас дэмжлэг шаардлагатай: хуулиар хоршооллыг өөрийгөө дэмжих ийлчилгээгээ хялбар, хямд инээр бий болгох; засгийн газар хоршоололтой хамтран ажиллах; засгийн газар хоршоололд зориулан ийлчилгээ нээх юм. Хоршооллууд НБХХ, ОУХБ, ХХААБ, ДБ, АХБ г.м. олон улсын байгууллагуудаас тусламж, дэмжлэг авдаг хэдий ч ихэнх нь амжилтанд хичрэхгүй байгаа нь хоршооллын байгууллагуудын нэр хиндэд муугаар нөлөөлж байна. Тэдгээр дэмжлэг тусалцаанууд нь хоршооллын хөгжлийг тогтвортой болгож чадахгүй байна. Өнгөрсөн хугацаанд олсон амжилт, нөөцөөр суралцаа чадвахыг дээшлүүлсэнээр тогтвортой хөгжилд хичр өөрөө өөрийгөө дэмжинэ. Ингэснээр нийгэм, эдийн засгийн хөгжилд ир динтэйгээр нөлөөлөх юм.

Товч орчуулга

**Таатай орчинг буй болгоход төр болон олон улсын хоршооллын хөдөлгөөний
өөрчлөгдөж байгаа үүрэг**

Ингрид Фишер

Хоршооллын хөгжлийн асуудлаарх зөвлөх

Улаанбаатар хот, Монгол Улс

2002 оны 5 дугаар сар

I. Оршил

“Хоршооллын хөдөлгөөн эд зүйлс ховор, дутмаг үед цэцэглэж элбэг хангалуун үед бэрхшээлтэй учирдаг” гэсэн үг байдаг. Энэ бол төр, олон улсын санхүүгийн байгууллагууд, хандивлагчид хийгээд шилжилтийн эдийн засгийн орнуудад үйл ажиллагаагаа явуулж буй олон улсын хоршооллын хөгжлийн байгууллагуудад хамааралтай үг.

Зүүн Европын болон Азийн орнууд 1990-ээд оны эхээр эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхлэх үе мэдээллийн технологийн хувьсгалтай давахцсан билээ. Эдгээр улс орон ядуу төсөвтэй байхын зовлоон бэрхшээлийг амсч байхад харьцангуй өндөр боловсролтой хүн ам нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон Интернетээр дамжин ирж буй мэдээллийн их давалгаанд автагдаж байна. Шилжилтийн эдийн засагтай орнуудын иргэд засгийн газруудаасаа эрс өөрчлөлтийг хэрэгжүүлэхийг шаарддаг боловч засгийн газрууд нь хөрөнгө мөнгөнийхээ бололцооноос шалтгаалан тэр болгоныг гүйцэлдүүлж чаддаггүй байна. Эдгээр орны засгийн газрууд давшилт өөрчлөлтийн хурдыг дийлэхгүй байгаагаар үл барам ихэнхи тохиолдолд ерөнхий дэд бүтэц болон нийгмийн халамж нь эрс буурч эсвэл огт алга болж байна. Эдүгээ Олон улсын хоршооллуудын холбооны (ОУХХ) хэв загвараар зохион байгуулагдаж буй хоршооллууд төр болон хувийн салбар дахь ажил эрхлэлтэд гарсан хоосон зайг дүүргэж бараа, үйлчилгээг нийлүүлэхээр гарч ирж байна. Үүний сацуу олон улсын санхүүгийн байгууллагууд болон хандивлагчид ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор хоршооллуудыг ихэд сонирхох болов. Энэхүү илтгэлд эдгээр хүчин зүйлс Монгол Улсад хэрхэн үйлчилж байгааг авч үзэх бөгөөд Азийн бусад орны туршлагын талаар ч мэдээллэх болно.

II. Төрийн үүрэг

Азийн шилжилтийн эдийн засагтай орнуудын засгийн газрууд сүүлийн жилүүдэд хоршооллуудын талаар өөр өөр бодлого явуулж байна. Хятадад ОУХХ-ны загварын хоршооллууд эрх зүйн статусгүй байгаа бөгөөд одоогийн

байдлаар төрөл бүрийн бэрхшээлүүдтэй тулгардаг нь тэдгээрийн хөгжилд ихээхэн сөргөөр нөлөөлдөг ажээ. Вьетнамын хоршооллын хуулиар төр хоршооллуудын үйл ажиллагаанд оролцох эрхтэй боловч төрийн оролцоо, зохион байгуулалттай хоршооллуудын зэрэгцээ ОУХХ-ны загварын хоршооллууд үйл ажиллагаа явуулах бололцоотой байдаг. Монгол Улсын Хоршооллын тухай хуулийн дагуу хоршооллууд эрх зүйн бие даасан субъектын статустай бөгөөд эдгээр 3 орноос Монгол Улсад хоршооллын хөдөлгөөн хамгийн их хөгжсөн билээ. Тийн авч, Монголын хоршооллын хөдөлгөөнд өөрийнхөө бүрэн нөөц бололцоог гаргахын тулд илүү таатай эрх зүйн орчин шаардлагатай байна.

Төр хоршооллын хөдөлгөөнийг эрх зүйн таатай орчинг бүрэлдүүлэх, зохистой бодлого явуулсанаар тэдгээрийн нөөц бололцоог бүрэн гаргаж олон нийтийн эрх ашигт дээд зэргээр үйлчлэх үйлсэд нь тус дэм үзүүлнэ.

Хоршооллын үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомжууд хоршоолол бүрийн үйл ажиллагааны онцлогт таарахаар уян хатан байх ёстой. Монгол Улсад эдүгээ мөрдөгдөж буй Хоршооллын тухай хуулиар хоршооллыг бүртгүүлэхийн тулд 9 хүн бүрэлдэх ёстой. Хэдийгээр 9 гэдэг нь том тоо биш боловч хөдөө орон нутагт зарим тохиолдолд хоршоолол үүсгэн байгуулах хүчин чадал, хүсэлтэй 9 хүнийг олоход хэцүү байдаг нь үнэн юм. Аж үйлдвэрийн болон ажилчны хоршооллын үйл ажиллагаа тусгай мэргэшсэн гишүүдээс шалтгаалах элбэг байдаг учир цөөхөн тооны гишүүдтэй хоршоолол үр дүнтэй ажиллах магадлал өндөр байдаг. Нөгөөтэйгүүр, хуримтлал, зээлийн хоршоолол олон тооны хийгээд төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсээс бүрэлдсэн байх шаардлагатай байдаг. Тэгэхээр хүн ам цөөтэй улс орон хууль тогтоомжуудаа уян хатан байлгах нь хоршооллуудын цаашдын хөгжилд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй.

III. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хандивлагчдын үүрэг

Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хандивлагчид хөтөлбөрүүдээ газар дээр нь илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой байдаг тул хоршооллуудтай хамтран ажиллах сонирхолтой байдаг. Хоршооллуудад олон улсын санхүүгийн байгууллагуудын туслалцаа, үйлчилгээ ихээхэн хэрэгцээтэй байдаг билээ. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон хоршооллуудын аль аль нь нийгмийн эмзэг давхаргын хэрэгцээг хангах асуудал дээр үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Тийм учраас олон улсын санхүүгийн байгууллагууд болон хоршооллууд хамтран ажиллах нь үр дүнтэй болдог юм. Гэхдээ олон улсын санхүүгийн байгууллагууд хоршооллуудад хэт энэрэнгүй хандаж хөрөнгө мөнгийг үр ашиггүй өгсөнөөр хоршооллуудыг үгүй болгохгүй байхад анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл олон улсын санхүүгийн байгууллагууд өмнөх тогтолцооны үеийнх шиг төрийн үүргийг орлож хоршооллуудыг хэт хараат болгох ёсгүй ажээ.

Тийм учраас төр, олон улсын санхүүгийн байгууллагууд болон олон улсын хоршооллын хөгжлийн агентлагууд дээр дурдсан сөрөг үр дагаваруудыг

багасгахад анхаарах хэрэгтэй. Зөв зохистой хоршооллын хөдөлгөөнийг хөгжүүлэхэд боловсрол болон сургалт чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Боловсрол, сургалт олгож явуулсанаар хоршооллууд бие даасан байдлаа хадгалж чадна.

IV. Олон улсын хоршооллын байгууллагуудын гүйцэтгэх үүрэг

Хоршооллын хөгжлийн байгууллагууд хоршооллуудыг ивээлдээ байлгахаасаа илүү жинхэнэ түншлэл бий болгон хамтран ажиллавал илүү үр өгөөжтэй байх болно. Бүрэлдэн тогтноход нь дэмжлэг үзүүлж байгаа хоршооллууд туслалцаа үзүүлэх хугацаа дууссаны дараа биеэ даан үйл ажиллагаагаа явуулах чадвартай болох ёстой гэдгийг хоршооллын хөгжлийн байгууллагууд ямагт санаж байх ёстой билээ. Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн (GTZ) туслалцаагаар Монголд байгуулсан Хоршооллын сургалтын төв нь зах зээлийн эдийн засгийн нөхцөлд хоршооллууд үйл ажиллагаагаа хэрхэн явуулах талаар сургалтыг амжилттай явуулж байна.

Олон улсын хоршооллын хөгжлийн байгууллагууд хоршооллуудын бие даасан байдал, ардчилсан хяналтын зарчмуудыг хангуулахын тулд хоршооллууд, Засгийн газар хийгээд олон улсын санхүүгийн байгууллагуудын хооронд зуучлагчийн үүргийг гүйцэтгэх ёстой.

V. Дүгнэлт

Монгол Улс хоршооллын хөдөлгөөний түүхэн сайхан уламжлалтай орон. Тус орны анхны хоршоолол 1921 онд байгуулагдаж байжээ. Шилжилтийн эдийн засагтай олон улс орон лугаа адил Монголын хоршооллууд нийгэмчиллийн үед ихээхэн хохирол амссан юм. Харин эдүгээ ард иргэд өдөр тутмын хэрэгцээг хангах, засгийн газар, хувийн салбарын хоорондахь ялгааг нөхөж бараа, үйлчилгээг олон түмэнд илүү хүртээлтэй болгох зорилгоор сайн дурын үндсэн дээр хоршооллуудыг дахин байгуулж байна. Санхүүгийн хоршооллуудыг эс тооцвол ихэнхи хоршооллууд хөдөө орон нутагт байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Учир нь гэвэл хувийн салбар хөдөө орон нутагт хөрөнгө оруулалт хийхийг ашиггүйд тооцдог бөгөөд харин Засгийн газар дээр дурдсан үйлчилгээг хөдөөд үзүүлэх бололцоогоор дутмаг байдаг ажээ. Хоршооллын хөдөлгөөн эд зүйлс ховор, дутмаг үед цэцэглэдэг гэдэг. Бэрхшээл хүндрэл учирахаар хүмүүс хамтран хоршоолол байгуулдаг нь үүний нотолгоо. Гэхдээ хоршооллууд хөрөнгө мөнгөний чадавхи, эрх зүйн тодорхой бус байдал, ялангуяа татварын хууль, сургалтанд хамрагдах бололцоогоор хомс, түүнчлэн олон нийт, санхүүгийн хүрээнийхэн хийгээд төрийн албан хаагчид хоршооллын талаар мэдээлэл муутай байдаг гэх зэрэг шалтгаанаас үүдэн дангаараа үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй учирдаг. Тийм учраас гадаадын агентлагууд, засгийн газар болон олон улсын хоршооллын хөгжлийн байгууллагууд дээрхи асуудлуудыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн анхдагч, хоёрдогч болон гурвдагч хоршооллын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай.

“Хоршооллын хөдөлгөөн эд зүйлс элбэг хангалуун үед бэрхшээлтэй учирдаг” гэсэн үг байдаг. Хоршооллууд олон улсын санхүүгийн байгууллагууд болон хандивлагч байгууллагуудын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэгч, туслалцааг нь дамжуулагч болдгийн хувьд зөвхөн хөрөнгө мөнгөний туслалцаа авах гэсэн хуурамч хоршооллуудыг бий болгохоос зайлсхийж хамтын ажиллагаа болон хоршоолол хоорондын зааг ялгааг сайтар тодорхойлж байх учиртай. Гадны туслалцаа хоршооллын хөдөлгөөнд зайлшгүй хэрэгцээтэй байдаг учраас сургалт, боловсролыг юуны өмнө үр дүнтэй олгох нь нэн хэрэгцээтэй. Хоршооллын асуудлыг хариуцсан сайд нарын уулзалтаас 1999 онд гаргасан Бээжингийн Тунхаглалын хоёр зүйлийг хоршооллын хөдөлгөөнийхэн анхааралдаа аван ажилдаа мөрдөж байх нь чухал. Үүнд:

- Хэдийгээр хоршооллын эд хөрөнгө нийтийнх боловч хоршооллын гишүүд хоршооллын хөдөлгөөний үзэл санааг гажуудуулахгүйгээр нэмэлт хөрөнгө олохыг эрэлхийлж байх ёстой.
- Хөгжлийн туслалцаа хоршооллын өсөлтөд чухал. Нэн ялангуяа түншлэлийн замаар хамтран ажиллах нь чухал бөгөөд сүлжээ бий болгон хамтран ажиллах хэрэгтэй.

Монголын хүн ам, газар зүй болон цаг агаарын онцлогийг харгалзан үзэхэд хоршооллууд тус улсад ихээхэн тохирдог. Алслагдсан хөдөө орон нутагт чухам хоршооллууд хүн ардын наад захын хэрэгцээний бараа, үйлчилгээг хүргэдэг билээ. Зарим орон нутагт тогтворжсон үйл ажиллагаатай хоршооллууд тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн гол хөдөлгөх хүч болон хамгийн найдвартай татвар төлөгчид нь болдог. Уян хатан бодлого явуулж, эрх зүйн таатай орчин бүрэлдүүлж, сургалт, боловсролд зөв хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө мөнгөөр туслалцаа үзүүлснээр хоршооллууд өөрчлөгдөн шинэчлэгдэж, үйл ажиллагаа явагдаж буй орон нутгаа бэхжүүлэх нь дамжиггүй.

Хоршооллыг амжилттай хөгжүүлэх хууль, шүүх,
захиргааны эрх зүйн арга зам

Илтгэгч: Данте Крагонья
Буэнос Айресын Их Сургууль

Оршил: Төр, хоршоолол ба хөгжил

Хэдийгээр Дэлхийн 2-р дайны дараа ихэд шүүмлэлтэд өртөх болсон ч, Төр, хоршооллын хоорондын харилцааны талаарх маргаан нь түүнээс урьд колончлалын үеэс үүдэлтэй ба онол болон практикийн хувьд үүсэн хөгжиж буй асуудал юм. Европын орнуудад хоршоолол нь Төрийн зүгээс эрх зүйн тусгай статус олгох хүрээнд үүссэн бол Ази, Африк, Латин Америкийн орнуудад Төрийн зүгээс тус улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд хүлээх үүрэгтэй салшгүй холбоотойгоор үүссэн байна. Үүнээс үзэхэд, буурай хөгжилтэй орнуудад, Төр, хоршооллын хоорондын харилцаа нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор үл барам, энэ чиглэлд хэрхэн хамтрах, цаашилбал, хоршоолол Төрийн түнш буюу Төрийн хөгжлийн зорилгыг гүйцэтгэгч нэмэлт хүчин мөн эсэх асуудал гарч ирэх болов.

Гэтэл сүүлийн жилүүдэд, хоршоолол Засгийн Газрын төлөөлөгч мэт болсон зарим улс орнуудын туулсан сөрөг үр дагаврын улмаас хоршооллыг гишүүдийнхээ эрх ашгийг биелүүлэх зорилготойгоор үүсгэн байгуулагдах, бие даасан байгууллага хэмээн шинэчилснээс үүдэж, Төр, хоршооллын хоорондын харилцааны асуудал цоо шинэ бүтэцтэйгээр судлагдах болсон юм. Уг асуудлыг, Олон Улсын Хоршооллын Холбоо/ОУХХ/-ны 1995 оны Манчестерийн Конгрессын хурлаар баталсан Хоршооллын Эрх зүй, бүтцийн талаарх Тунхаглал (Statement on the Cooperative Identity) хийгээд КОПАК /СОРАС/-аас боловсруулан, НҮБ-ын санал болгосон Хоршооллыг Дэмжих Таатай орчин бүрдүүлэх талаарх Заавартчлагатай нийцүүлэн үйлдвэр хөгжсөн, шилжилтийн болон хөгжиж буй болон бүх улс орнуудын нийтлэг хүрээг хамруулан өргөтгөсөн байна. Улмаар, хоршоолол өөрийн гишүүдийн эдийн засгийн нөхцлийг бие даан дээшлүүлэхийг эрмэлздэг ба чингэхдээ тухайн нийгмийн сайн сайхан, хөгжил дэвшилтэд давхар хувь нэмэр оруулдаг учиртай бөгөөд өнөөгийн ярилцлага чухам энэ хүрээнд чиглэгдэнэ.

Хоршооллын Нийтлэг шинж чанар ба Үндэсний эрх зүйн хэм хэмжээ

Нийтлэг эрх ашиг, хэрэгцээгээ өөр хоорондоо нийлэн, зорилгоо нэгтгэсэн хувь хүмүүсийн чөлөөт эрмэлзлийг илэрхийлсэн үнэт зүйлийнхээ хувьд хоршоолол нь үндэсний хязгаараас гадуур, нийтлэг шинж бүтэцтэй бөгөөд Хоршооллын Эрх зүй, бүтцийн талаарх Тунхаглалд энэхүү нийтлэг шинж бүтцийн хүрээ, түүний тодорхойлолт, байгууллага, зохион байгуулалтын зарчмыг тодорхойлжээ.

Ийнхүү, хоршооллыг эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг эрх ашиг, хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дураараа нэгдсэн хувь хүмүүсийн үүсгэн байгуулан, ардчилсан зарчмаар удирдах, хамтарсан өмчийн хэвшил гэж тодорхойлсон аж. Ийнхүү, хоршооллын гол хүчин зүйл бол бие даасан, үүрэг хариуцлагатай, гишүүдийн эрх тэгш, шударга ёс, нээлттэй байдал зэрэг ардчилсан зарчимд тулгуурласан байх ёстой. Хоршоолол нь нийтлэг шинж чанараас гадна тухайн улс орны газар зүй, түүх, улс төр, соёлын онцлогтой салшгүй холбоотой учир эрх зүйн хүрээнд тухайн улсын өвөрмөц онцлог, эрх ашиг нь тусгагдах нь гарцаагүй юм. Ийм эрх зүйн зохицуулалт хийхдээ хоёр асуудлыг анхаарах нь чухал: нэг талаас, нийтлэг шинж чанарыг хэт онцгойлон тухайн улс орны онцлогийг үл харгалзан нэг хэвийн хууль тогтоомж гаргах, нөгөөтэйгүүр, үндэсний онцлогийг хэт даймжруулан байгууллагын нийтлэг шинж чанар умартахаас сэргэмжлэн хоршооллын дээрх хоёр онцлогийг оновчтой хослуулан шийдвэл зохимжтой билээ. Эрх зүйн ийм оновчтой шийдэл нь ярвигтай хийгээд их хүч хөдөлмөр шаардах нь мадаггүй.

Хоршооллыг зохицуулах хууль тогтоомжийн ач холбогдол

Хоршооллын хууль тогтоомж нь Төрийн зүгээс хоршооллын талаарх байр суурийг нэгтгэсэн, түүний шинж чанар, эрх үүрэг, үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулах зорилготой байдаг. Зарим улс хоршооллын тусгай хууль тогтоомжгүй байдаг ч, бусад цогцолбор хууль зүйн, тухайлбал, Аж Ахуйн буюу Иргэний хуульд агуулагдах, эсвэл эрх зүйн тусгай актуудаар зохицуулдаг. Ийм хувилбаруудаас зөвхөн хоршооллоор тусгайлсан, түүний төрөл зүйл, эрх зүйн зохицуулалтыг агуулсан хууль тогтоомж зөвлүүштэй бөгөөд үүний ач холбогдол нь олон хууль тогтоомжоор зохицуулснаас илүү цэгцтэй бөгөөд тодорхой байдгаараа давуу талтай юм. Хоршоолол нь тусгайлсан хууль тогтоомжинд агуулагдсан тохиолдолд ч нэгэнт бусад хууль, эрх зүйн зохицуулалтад бас хамаардаг тул аливаа эрх зүйн зөрчлийг зохицуулах механизм уг хуулинд тусгагдсан байх нь зохистой. Улмаар, зорилго болон гол зохицуулалтыг хоршооллын тусгайлсан хуулиар чухалчлан тогтоож, бусад журмуудыг холбогдох дагавар хууль, захиргааны журам болон тогтоолд хамруулж болдог.

Хоршооллыг тодорхойлох нь

Аливаа хууль тогтоомжинд хоршооллыг зөв тодорхойлох нь онц чухал бөгөөд корпорац, нийгэмлэг гэх мэт бусад аж ахуйн нэгжээс ангид эрх зүйн статус, онцлог байр суурийн үндэс нь болно. ОУХХ-ны баталсан хоршооллын тодорхойлолт, зарчмууд, 127/66 тоот НҮБ-ийн Зөвлөмжид заасан ерөнхий чиг, зааварт тулгуурлан өөрийн үндэсний онцлогт тохируулан тодорхойлох нь зүйтэй.

Үүсгэн байгуулах ба бүртгэл

Хоршооллын хууль нь бусад дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдах эрх зүйн этгээдийн адил эрх зүйн эрх, үүрэгтэй, түүний эрх зүйн статусыг хэрхэн авах журмыг оновчтой заах ба хэт өндөр шаардлага, зардалгүй байх бөгөөд бүртгэлийг эрх мэдэл бүхий бүртгэлийн албанд буюу компанийн бүртгэлийн газар үүсгэн байгуулах шаардлага хангасан даруйд бүртгүүлнэ. Бүртгэлийн алба нь мэдээлэл авах сонирхолтой хувь хүн, нийтэд өргөнөөр үйлчлэх ба бүртгэснийг баталж гэрчилгээ олгоно. Хоршооллын эрхийг аливаа үндэслэлээр олгоогүй тохиолдолд, нэхэмжлэгч уг шийдвэрийг шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй байх ёстой.

Гишүүн ба түүний эрх ба үүрэг

Нийтлэг эрх ашиг, хэрэгцээгээ нэгтгэн шийдэх зорилготойгоор үйлчилгээ явуулж, хариуцлага хүлээх чадвартай хэн бүхэнд хоршоололд гишүүнээр элсч болох ба арьс өнгө, үндэс угсаа, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэг, хүйсээр ялгаварлахгүй зарчмын үндсэн дээр сайн дурын, нээлттэй шийдэл байх ёстой. Улмаар, гишүүний эрх ба үүргийг /тухайлбал ардчилсан зарчмаар хоршооллын удирдлагад оролцох, хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх/ ерөнхийлөн хуульчлан тогтоож, нарийн журмуудыг холбогдох дагавар хуулиар зохицуулна.

Санхүүжилт ба эд хөрөнгө

Хоршоолол нь аж ахуйн нэгжийн хувьд гишүүдийн эрх ашгийн зорилгод нийцүүлэн санхүүжигдэх ба санхүүгийн нөөц нь гол төлөв эд хөрөнгө ба хуваарилагдаагүй илүүдэл хөрөнгөөс бүрдэнэ. Хувьцааны нөхөн төлбөрийг хүүгийн хэлбэрээр олгох боломжтой бөгөөд санхүүжилтын механизмыг хоршооллын үйлчилгээний хувиар эсвэл эргэлтийн хөрөнгөний эдийн засгийн бололцоот хэмжээг тооцоолох зэрэг аргаар зохицуулах боломжтой. Хуваарилагдаагүй буюу санхүүгийн илүүдэл хөрөнгийн тодорхой хэсгийг нийт хамтарсан хөрөнгөд шилжүүлэх, түүнчлэн гишүүдэд хоршооллын гүйлгээний хувиар тооцоолон хувааж хувьцааны хэлбэрээр өгөх боломжийг хуульд тогтоох ба түүнд аливаа аж ахуйн нэгжийн адил банк болон бусад санхүүжилтийн хэлбэрүүд нээлттэй байх ёстой. Бусад улсын жишгээс үзэхэд, санхүүгийн илүүдэл хөрөнгийн тодорхой хувийг хоршооллын гишүүдийн боловсролд зарцуулахыг хуульчилсан байдаг.

Нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн аудит

Хоршооллын данс бүртгэл гишүүдийн ба гуравдагч этгээдийн эрх ашиг, түүний эдийн засаг, гүйлгээний хэмжээтэй нийцсэн, шударга бөгөөд найдвартай байна. Санхүүгийн тайлангийн хугацааг хуульд заан, хоршооллын гишүүд хянасны дараагаар зохих бүртгэлийн албанд бүртгүүлэн, олон нийтэд танилцуулах боломжтой. Түүнчлэн, хоршооллын тайлан бүртгэлийг хөндлөнгийн нягтлангаар шалгуулах нь зүйтэй.

Хоршооллын бүтэц, зохион байгуулалт

Хоршооллын зохион байгуулалтын бүтэц нь идэвхитэй менежмент, ардчилсан удирдлага болон дотоод хяналтаас бүрдэх бөгөөд зөв зохион байгуулалт нь үйл ажиллагааг амжилттай явуулахад нөлөөлдөг. Эдгээр нь удирдлагын буюу ерөнхий зөвлөлийн хурал, захиргааны буюу захирлын зөвлөл, хяналтын буюу хянан шалгалтын хороо гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй байх ба түүний ерөнхий эрх мэдэл, үүргийг хуульчлан тогтооно. Ерөнхий зөвлөлийн хурлаар бүх гишүүд санал өгөх эрхтэй ба бусад бүрэлдэхүүний гишүүд, хөндлөнгийн нягтланг томилох, жилийн төсөв, нийт хөрөнгө оруулалт, санхүүгийн тайланг батлах болон шинэ үйл ажиллагаа, дотоод журмыг өөрчлөх гэх мэт асуудлыг шийднэ. Захирлын зөвлөл нь цөөн гишүүдээс бүрдэх ба удирдлага, захиргааны шинж чанартай асуудал, тухайлбал ерөнхий зөвлөлийн хурлын тогтоол, дотоод журмыг өөрчлөлтийг хэлэлцэх, санхүүгийн тайланг ерөнхий зөвлөлийн хуралд оруулах гэх мэт үүрэгтэй. Хянан шалгалтын хороо нь дотоод журмын дагуу томилогдсон гишүүнээс бүрлэх ба захирлын зөвлөлийн үйл ажиллагааг хянаж дүгнэлтийг ерөнхий зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг үүрэгтэй байна.

Хоршооллыг татан буулгах нь

Гишүүдийн олонхийн саналаар, хугацаа дууссан, зорилгоо гүйцэтгэх чадваргүй, бүртгэлийн шаардлага хангаагүй гэх мэт хуульд заасан үндэслэлийн дагуу хоршооллыг татан буулгаж болно. Уг шийдвэрийг захирлын зөвлөл буюу тусгай томилогдсон хороо хууль, дотоод журмын дагуу гүйцэтгэх бөгөөд хоршоолол данпуурсан тохиолдолд данпуурлын хуулийн дагуу шийдвэрлэн, албан бүртгэлээс хасна.

Байгууллагын төлөөлөл ба дотоод хяналт

Хоршоолол нь гишүүдийн эрх ашиг, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутаг, улс, бүсийн болон олон улсын хэмжээнд ажиллахдаа эдийн засаг, нийгэмд хувь нэмэр оруулдаг тул тэдний нийтлэг эрх ашгийг засгийн газар, төрөөс хамгаалах зохих хуульчилсан төлөөлөлтэй байх ёстой.

Хууль дүрэм, завартай үйл ажиллагаа нийцэж буй эсэхийг хоршоолол юуны өмнө өөрөө тодорхойлдог үүрэгтэй, дотоод хяналтын тогтолцоотой байх шаардлагатай. Гэтэл зарим улсын жишгээр, Төрийн байгуулага буюу бүртгэлийн алба хяналтын үүргийг хариуцаж, зарим тохиолдолд хоршооллыг сурталчлах гэх мэт хянан шалгалттай харшилдах үйл ажиллагаа явуулж байна.

Хоршооллын үндэсний алба

Дээр дурдсанчлан, зарим улсад Төрийн байгуулага буюу бүртгэлийн алба хоршооллыг бүртгэх, түүнд хяналт тавих, хоршооллыг сурталчлах үүргийг хариуцаж Төрөөс төвлөрсөн бодлого хэрэгжүүлж байна. Нөгөө талаас хоршооллын асуудлыг Төр, хоршооллын хөдөлгөөний төлөөлөгчид хамтран

зохицуулах нь хоорондын эрх ашиг, сонирхлыг хамгаалах илүү үр дүнд хүрсэн байна. Хоршооллыг жинхэнэ утгаар нь, ОУХХ-ны бие даасан, төрийн хэт хамаарлаас ангид байх зарчмыг тулгуурлан хөгжүүлбэл нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг дээшлүүлэх нь дамжиггүй.

Хоршоолол хоорондын маргааныг шийдвэрлэх

Хоршоолол ба гишүүд хоорондын маргаан гарахад түүнийг хугацаа алдалгүй, эдийн засгийн засгийн аргаар шийдвэрлэх олон улсад түгээмэл механизм бол арбитрын шүүх юм. Арбитраар эсвэл зуучлалаар маргааныг шийдвэрлэх нь шүүхтэй харьцуулахад өртөг бага, харьцангуй хурдан байдгаараа давуу талтай. Маргааныг ийнхүү шийдвэрлэж чадахгүй бол талууд энгийн шүүхэд хандах нь зохистой.

Хоршооллын татвар

Хоршооллын онцлог, нийгэм эдийн засагт оруулах хувь нэмрийг тооцон татвараас хөнгөвчлөх, чөлөөлөх бодлогыг дэмжсэн үзэл түгээмэл билээ. Юутай ч болов ашгийн төлөө бусад хэвшлийн адил татвар төлөх ёсгүй гэдэг гарцаагүй. Улс орон бүр өөрийн онцлогтой нийцүүлэн татварын хэмжээг ногдуулах хэдий ч ОУХХ-ны баталсан Хоршооллын Эрх зүй, бүтцийн талаарх Тунхаглалд зааварласны дагуу зохицуулахыг тэмдэглүүштэй.

Товч орчуулга

“НҮБ-ын зааварчлага ба Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын /ОУХБ/
Хоршооллыг дэмжих чиглэлээр гаргасан шинэ зөвлөмж”

Илтгэгч: Анн-Брит Нипьерд

ОУХБ, Хоршооллын бодлогын тасаг

ОУХБ-аас Хоршооллыг дэмжих талаарх байр суурь

ОУХБ нь нийгмийн шударга ёс, олон улсын хүний ба хөдөлмөрийн эрхийг хөгжүүлэн сахиулах зорилгоор 1919 онд байгуулагдсан НҮБ-ын тусгай агентлаг юм. Хоршооллыг дэмжин хөгжүүлэх нь дэлхий дахинаа олон сая хүний хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтойг хүлээн зөвшөөрч, тус байгууллагын Үндсэн Хуульд заасны дагуу хоршооллын техникийн үйлчилгээг 1920 онд бий болгосон билээ.

ОУХБ нь хоршооллыг ардчилал, эрх тэгш ёсонд тулгуурласан, гишүүн ба нийгмийн эрх ашгийг хамгаалах, эдийн засгийн асуудлыг шийдэхэд үнэтэй хувь нэмэр оруулдаг аж ахуйн нэг хэлбэр бөгөөд түүний хөгжил нь тус байгууллагын зорилтыг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлнө гэж үздэг.

ОУХБ-ын Хоршооллын бодлогын тасаг гишүүн орнуудад техникийн хамтын ажиллагаа, тухайлбал хоршооллын шинэтгэл, хууль тогтоомж, ажил эрхлэлт, хүний нөөцийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, дотоод эдийн засгийг хөгжүүлэх, түүнчлэн нийтийг мэдээллээр хангах, арга, аргачлалыг сайжруулах зэрэг үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уг хөтөлбөр нь НҮБ-ын тогтолцоонд хамгийн өргөн хүрээтэйд тооцогддог.

Хоршооллын бодлогын тасаг нь ОУХБ-ын хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах ажлын хүрээнд хоршооллыг албан бус эдийн засгийн хамгийн бага үр ашигтай хэсэгт байгуулж, улмаар тэдний нийгмийн хамгаалалтыг хоршооллоор дамжуулан шийдвэрлэж болох түүний давуу тал дээр онцгой анхааран ажиллаж байна.

II. ОУХБ ба зааварчлага

ОУХБ нь хүний ба хөдөлмөрийн түгээмэл эрхийг хэрэгжилтийг заавар, стандартчиллаар зохицуулдаг. Хөдөлмөрийн эрх, ажил эрхлэлт, хүний нөөцийн хөгжил болон жижиг ба дунд үйлдвэр, хоршооллыг хөгжүүлэх зэрэг асуудлаар ОУХБ –ын шийдвэр гаргах зөвлөл буюу Олон Улсын Хөдөлмөрийн Зөвлөлгөөн /ОУХЗ/ хэлэлцэн Гэрээ буюу Зөвлөмжийн хэлбэрээр стандарт, заавар баталдаг. Хөгжиж буй орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүргийн талаарх 127-р Зөвлөмжийг ОУХЗ-ийн 50-р чуулганаар 1966 оны 6-р сард баталсан юм.

III. Хоршооллын талаарх шинэ чиг баримтлал

1966 оноос хойш дэлхий дахинаа гарсан улс төр, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүдийг харгалзан үзэж ОУХЗ-өөс 1999 оны 3-р сард шинэ түгээмэл зарчим батлахаар шийдэн, хоршооллыг улам бие даасан, нийгэм эдийн засгийн асуудлыг шийдвэрлэн, улмаар тэдний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг үндэслэлээр 127-р Зөвлөмжид шинээр тусгах хэлэлцүүлэг өрнөж байна. Уг асуудлаарх анхны хэлэлцүүлэг 2001 оны 6-р сард явагдсан бөгөөд эцсийн дүгнэлтүүдийг гишүүн орнуудын өгсөн саналын үндсэн дээр Зөвлөлгөөний 90-р чуулганаар энэ оны 6-р сард батлах юм.

IV. Хоршооллын талаарх НҮБ-ын зааварчлага

1996 оны НҮБ-ын 51/52 тоот Тогтоолоор НҮБ-ын Ерөнхий Ассемблей хоршооллын үйл ажиллагааг зохицуулах захиргаа, эрх зүйн журмыг хянаж, үндэсний хөгжилд зохистой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх нөхцлийг бий болгохыг гишүүн улсуудын Засгийн Газарт уриалсан юм. Цаашилбал, 1999 оны НҮБ-ын Ерөнхий Ассемблей 54/123 тоот Тогтоолын дагуу НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн Дарга 2002 оны 1-р сарын 18-ны А/RES/56/114 Тогтоол гарган хоршооллын талаарх НҮБ-ын шинэчилсэн зааварчлага боловсруулахад санал оруулах, хоршооллын болон үндэсний хөгжилд зохистой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх захиргаа, эрх зүйн нөхцлийг бий болгохыг гишүүн орнуудын Засгийн Газарт уламжилсан билээ. Энэ хүрээнд, НҮБ, олон улсын байгууллага, тив ба дотоодын хоршооллын удирдлагуудтай хамтран гишүүн орнуудын хоршооллыг дэмжих таатай орчин бүрдүүлэх явцад дэмжлэг үзүүлэх сургалт, туршлага солилцох зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

V. НҮБ-ын зааварчлага ба ОУХБ-ын Хоршооллыг дэмжих чиглэлээр санал болгосон зөвлөмж

НҮБ-ын заавар ба ОУХБ-ын Хоршооллыг дэмжих чиглэлээр зөвлөмж нь гишүүн орнууд, олон улс ба дотоодын хоршооллын хөдөлгөөнүүдийн хөдөлмөр, нухацтай хэлэлцээрийн үр дүн бөгөөд түүний гол зорилт нь дэлхий дахинаа хоршооллыг дэмжих таатай орчин бүрдүүлэх, түүнд түлхэц үзүүлэхэд оршино. Дээрх хоёр баримтын агуулгын ерөнхийг харьцуулан тоймлон доорх нийтлэг зарчмуудыг өгүүлж болно.

а/ Түгээмэл шинж

НҮБ-ын Зааварчлага бүх гишүүн орнуудад үйлчилдэг ба ОУХБ-ын зөвлөмж ч мөн адил бүх гишүүн орнуудад үйлчилнэ.

б/ Тодорхойлолт

НҮБ-ын Заавартчлага Олон Улсын Хоршооллын Холбоо/ОУХХ/-ноос 1995 гаргасан хоршооллын тодорхойлолт дээр үндэслэн дотоодын хууль тогтоомжид оруулахыг зөвлөжээ. Харин ОУХБ-ын зөвлөмжид ОУХБ болон ОУХХ-ын тодорхойлолтыг хослуулахыг санал болгожээ.

в/ Хоршооллын үнэт зүйл ба зарчим

НҮБ-ын Зааварчлага болон ОУХБ-ын зөвлөмжид хоршооллыг үнэт зүйл, ёс зүй ба зарчимд тулгуурласан аж ахуйн нэгж ба нийгмийн байгууллага гэж тусгажээ.

г/ Хоршооллын эрх тэгш ёс

Төрөөс хоршооллын талаар бусад аж ахуйн нэгжээс ялгаагүй таатай орчинг бүрдүүлэх захиргаа, эрх зүйн нөхцлийг бий болгохыг санал болгожээ.

д/ Хоршооллын биеэ даасан байдал

Төрөөс хоршооллын бодлогыг зохицуулавч дотоод хэрэгт нь шууд оролцохгүй хийгээд бие даасан байдлыг зөрчихгүй байхыг НҮБ-ын Зааварчлагад заажээ. ОУХБ-ын зөвлөмжид Төрөөс хоршооллын дотоод хэрэгт нь шууд оролцохгүй талаар дурьдаагүй ч бие даасан байдлыг нь бусад аж ахуйн нэгжийн адил эрхэмлэхийг санал болгожээ.

е/ Гишүүдийн хэрэгцээнд төвлөрсөн байдал

НҮБ-ын Зааварчлагад хоршоолол нь гишүүдийн хувийн хэрэгцээг хангах, дээшлүүлэх бодлого баримтлахаар тусгасан байна. Харин ОУХБ-ын зөвлөмжид хоршооллыг гишүүдийн хэрэгцээг хангах хэрэглүүр гэж үзсэн ба хоршооллыг хөгжүүлэх Төрийн үүргийг цохон тэмдэглэсэн байна.

ё/ Үйлчилгээ, хүний нөөцийн хөгжил ба санхүү, зээлийн асуудал

ОУХБ-ын зөвлөмжид хоршооллын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, судалгаа, санхүү, хөрөнгө оруулалт мэлээлэл, технологи, менежмент, хууль ба татварын зөвлөх зэрэг туслах үйлчилгээний арга замыг ашиглахыг зөвлөжээ. НҮБ-ын Зааварчлагад энэ асуудал нарийн тусгагдаагүй ч хоршооллын гишүүдийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг тусгажээ.

ж/ Бодлого боловсруулахад хоршооллын хөдөлгөөний оролцоо

НҮБ-ын Зааварчлага болон ОУХБ-ын зөвлөмжид хоршооллыг түүнтэй холбогдолтой хууль, журмыг боловсруулан батлахад оролцохыг заажээ.

з/ Бусад хүчин зүйл

НҮБ-ын Зааварчлага болон ОУХБ-ын зөвлөмж нь тус хоёр байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой онцлогийг тусган мэдээлэл, судалгаа, статистикийн мэдээллийн талаарх олон улсын хамтын ажиллагааг өргөтгөхийг уриалжээ. Нөгөөтэйгүүр, ОУХБ-ын зөвлөмжид ажилчдын эрхийн асуудал онцлон тусгагдсан.